

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/055/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баян-Өлгий аймаг 2025 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: С.Нурлан Утас: 99103281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУЯНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Х.БАЯНБААТАР ТАНАА

2025.02.12 № 35
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөг

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,229,395.00</u>	<u>14,229,395.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	14,229,395.00	14,229,395.00
354	Хангамжийн материал	14,229,395.00	14,229,395.00
35410	Бичиг хэргийн материал	774,000.00	774,000.00
35420	Аж ахуйн материал	1,164,716.00	1,164,716.00
35470	Бусад хангамжийн материал	12,290,679.00	12,290,679.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,180,432,834.28</u>	<u>3,238,851,092.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,180,432,834.28	3,238,851,092.01
392	Биет хөрөнгө	3,175,111,595.28	3,232,771,713.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	495,479,489.00	508,732,189.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(227,904,371.35)	(235,865,134.71)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	201,294,700.00	212,149,995.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(131,046,368.50)	(136,749,662.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,179,103.00	78,227,153.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,744,642.73)	(39,358,397.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,267,412.00	36,752,752.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,341,791.53)	(26,045,246.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,309,445,040.21	4,325,445,040.21
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,497,516,974.82)	(1,497,516,974.82)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	7,000,000.00	7,000,000.00
393	Биет бус хөрөнгө	5,321,239.00	6,079,378.67
39301	Програм хангамж	3,106,639.00	3,876,639.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,683,400.00)	(1,695,260.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,898,000.00	3,898,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,194,662,229.28</u>	<u>3,253,080,487.01</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>14,253,457.00</u>	<u>14,253,457.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,253,457.00	14,253,457.00
413	Өглөг	14,253,457.00	14,253,457.00
4136	Бусад өглөг	14,253,457.00	14,253,457.00
41361	Байгууллагад төлөх өглөг	14,253,457.00	14,253,457.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,180,408,772.28</u>	<u>3,238,827,030.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,180,408,772.28	3,238,827,030.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	823,557,165.00	823,557,165.00
51101	Өмч: - төрийн	823,557,165.00	823,557,165.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,475,356,779.26	1,540,522,336.99
51210	Өмнөх үеийн үр дүн	1,475,356,779.26	1,482,104,079.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	58,418,257.73

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	881,494,828.02	874,747,528.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,194,662,229.28</u>	<u>3,253,080,487.01</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	673,412,250.00	936,819,207.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	145,836,989.00	73,706,050.00
120	Нийтлэг татварын бус орлого	145,836,989.00	73,706,050.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	73,706,050.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	73,706,050.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	145,836,989.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	527,575,261.00	863,113,157.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	516,789,720.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	516,789,720.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,785,541.00	22,519,028.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,785,541.00	18,519,028.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	840,594,129.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	840,594,129.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	797,835,693.99	878,400,949.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	797,835,693.99	878,400,949.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796,641,693.99	841,116,320.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351,601,188.04	587,433,556.33
210101	Үндсэн цалин	254,018,593.47	327,955,339.66
210102	Нэмэгдэл	85,982,594.57	243,314,099.67
210104	Урамшуулал	-	16,164,117.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,600,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,232,500.00	77,441,700.00
210201	Тэтгэврийн даатгал	28,718,100.00	52,660,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,378,600.00	6,195,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,710,200.00	3,097,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	668,400.00	3,097,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,757,200.00	12,390,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,020,850.00	59,644,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,125,000.00	1,750,661.00
210302	Түлш, халаалт	62,895,850.00	57,893,739.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,496,028.78	30,711,078.00

210401	Бичиг хэрэг	2,367,900.00	3,428,300.00
210402	Тээвэр, шатахуун	16,479,460.00	23,719,278.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,510,968.78	3,146,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	137,700.00	297,000.00
2105	Нормативт зардал	398,250.00	611,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	398,250.00	611,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,597,319.00	3,036,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	562,619.00	926,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	76,800.00	50,000.00
210604	Урсгал засвар	957,900.00	2,060,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,856,000.00	4,224,000.00
210702	Дотоод албан томилолт	2,856,000.00	4,224,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,958,040.00	18,656,143.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,989,620.00	15,641,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	189,720.00	10,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	987,800.00	2,926,023.67
210807	Газрын төлбөр	119,900.00	46,120.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	26,200.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	297,481,518.17	59,357,942.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,911,331.00	25,770,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	735,050.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	282,835,137.17	33,587,792.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,194,000.00	37,284,629.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	714,000.00	37,284,629.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	36,984,629.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	480,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	480,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(124,423,443.99)</u>	<u>58,418,257.73</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(124,423,443.99)</u>	<u>58,418,257.73</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>527,575,261.00</u>	<u>863,113,157.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	527,575,261.00	863,113,157.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	516,789,720.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	516,789,720.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,785,541.00	22,519,028.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,785,541.00	18,519,028.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	840,594,129.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	840,594,129.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>515,525,261.00</u>	<u>844,813,157.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	515,525,261.00	844,813,157.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,331,261.00	807,528,528.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	351,536,892.22	587,433,556.33
210101	Үндсэн цалин	260,937,192.22	328,755,339.66
210102	Нэмэгдэл	78,999,700.00	242,514,099.67
210104	Урамшуулал		16,164,117.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,600,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,232,500.00	77,441,700.00
210201	Тэтгэврийн даатгал	28,718,100.00	52,660,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,378,600.00	6,195,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,702,900.00	3,097,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	675,700.00	3,097,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,757,200.00	12,390,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,062,500.00	60,175,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,125,000.00	1,560,000.00
210302	Түлш, халаалт	62,937,500.00	58,615,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,557,552.00	30,850,523.95
210401	Бичиг хэрэг	1,780,000.00	2,860,745.95
210402	Тээвэр, шатахуун	16,679,652.00	23,219,278.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,770,900.00	4,353,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	297,000.00
2105	Нормативт зардал	430,000.00	611,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	611,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,885,000.00	3,300,877.72
210601	Багаж, техник, хэрэгсэл	714,000.00	1,171,077.72
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	69,800.00

210604	Урсгал засвар	1,100,000.00	2,060,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,072,307.78	4,224,000.00
210702	Дотоод албан томилолт	3,072,307.78	4,224,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,418,120.00	17,189,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,578,620.00	16,154,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	6,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	10,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	838,000.00	928,600.00
210807	Газрын төлбөр	131,000.00	46,120.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	11,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,136,389.00	26,300,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,422,389.00	25,238,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,000.00	1,062,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,194,000.00	37,284,629.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	714,000.00	37,284,629.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		36,984,629.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	480,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	480,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,050,000.00</u>	<u>18,300,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,050,000.00	18,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,050,000.00	18,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,050,000.00	18,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,050,000.00	18,300,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(12,050,000.00)</u>	<u>(18,300,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(0.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөг

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөг

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	891,318,400.00	840,594,129.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	891,318,400.00	840,594,129.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,045,400.00	803,309,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	619,532,400.00	587,433,556.33
210101	Үндсэн цалин	334,328,000.00	328,755,339.66
210102	Нэмэгдэл	266,424,400.00	242,514,099.67
210104	Урамшуулал	18,780,000.00	16,164,117.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,441,700.00	77,441,700.00
210201	Тэтгэврийн даатгал	52,660,300.00	52,660,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,195,300.00	6,195,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,097,700.00	3,097,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,097,700.00	3,097,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,390,700.00	12,390,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,180,800.00	58,805,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,500,000.00	1,500,000.00
210302	Түлш, халаалт	57,680,800.00	57,305,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,284,000.00	29,920,245.95
210401	Бичиг хэрэг	2,962,000.00	2,860,745.95
210402	Тээвэр, шатахуун	22,798,500.00	22,289,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,353,500.00	4,353,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,000.00	297,000.00
2105	Нормативт зардал	700,000.00	611,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	611,500.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,886,600.00	2,300,877.72
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,243,400.00	1,171,077.72
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,200.00	69,800.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,060,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,100,000.00	3,544,000.00
210702	Дотоод албан томилолт	7,100,000.00	3,544,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,857,900.00	33,189,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,494,500.00	32,154,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	513,000.00	6,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	184,200.00	10,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,400.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	981,000.00	928,600.00
210807	Газрын төлбөр	128,500.00	46,120.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	44,300.00	11,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,062,000.00	10,062,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000.00	9,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,062,000.00	1,062,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,273,000.00	37,284,629.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,273,000.00	37,284,629.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,222,000.00	36,984,629.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,051,000.00	300,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	891,318,400.00	840,594,129.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	891,318,400.00	840,594,129.00
132001	Орон нутгийн төсвөөс	891,318,400.00	840,594,129.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.00	22.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	7.00	7.00

650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00
--------	-----------------------------	------	------

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,519,028.00	22,519,028.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,519,028.00	22,519,028.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,519,028.00	22,519,028.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,370,000.00	1,370,000.00
210301	Гэрэл, цахилгаан	60,000.00	60,000.00
210302	Түлш, халаалт	1,310,000.00	1,310,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	930,278.00	930,278.00
210402	Тээвэр, шатахуун	930,278.00	930,278.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	680,000.00	680,000.00
210702	Дотоод албан томилолт	680,000.00	680,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,538,750.00	18,538,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,538,750.00	18,538,750.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,519,028.00	22,519,028.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,519,028.00	22,519,028.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,519,028.00	18,519,028.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Буянт сумын Засаг даргын тамгын газрын эрхэм зорилго нь “Аймаг, сумын бодлогын хэрэгжилтийг шуурхай удирдлагаар хангах, үр дүнг шударгаар тооцох замаар төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэддээ чанартай үйлчилгээ үзүүлж улмаар орон нутгийн хөгжлийг тэтгэх чадварлаг захиргааны байгууллагыг төлөвшүүлнэ” гэсэн чиг үүрэгтэйгээ нийцсэн зорилго зорилт дэвшүүлж хэрэгжүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Буянт сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Буянт сумын Засаг даргын тамгын газар нь дотоод аудитын нэгжгүй, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 18 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/299 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58.4 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	0	0	0
Бараа материал	14,229.4	14,229.4	0
Үндсэн хөрөнгө	3,180,432.8	3,238,851.1	58,418.3
Нийт хөрөнгө	3,194,662.2	3,253,080.5	58,418.3
Өр төлбөр	14,253.4	14,253.4	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,180,408.8	3,253,080.5	58,418.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,194,662.2	3,253,080.5	58,418.3

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгийн дансанд өөрчлөлт гарсан байна.

Оны эхэнд бараа материалын данс 14.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр нийт 179.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч 179.5 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 14.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Үндсэн хөрөнгийн данс 92.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 18.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 73.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 14.6 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 14.2 сая төгрөг ба оны эцэст өөрчлөлт гараагүй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 58.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засаг даргын тамгын газар нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 842.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийт зарлагыг 842.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 49.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 891.3 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 891.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 840.6 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан ба төсвийн нийт зардлын гүйцэтгэл 840.6 сая төгрөг буюу 92.04 хувьтай байна. Энэ нь 50.7 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	670,006.5	645176.9	24,829.6	96.3
2	80102-Туслах үйл ажиллагааны зардал	136,287.9	121,297.6	14,990.3	89
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	46,273.0	37,284.6	8,988.4	80.6
4	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0	100.0
5	81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөх	33,751.0	31,835.0	1,916.0	94.3
	Дүн	891,318.40	840,594.10	50,724.30	92.04

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй, Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 16.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 25.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын тамгын газраас 4.0 сая төгрөг, БОХС-гийн барьцаа 7.6 сая төгрөг, Статистикийн сургалт, хагас жилийн мал тооллого тээвэр шатахуун 1.5 сая төгрөг, Сумын тэжээлийн фонд 2.0 сая төгрөг, Халуун усны халаалт гэрэл цахилгаан 7.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч, үүнээс гэрэл, цахилгаан, түлш, халаалтын зардалд 1.4 сая төгрөг, тээвэр шатахууны зардалд 0.9 сая төгрөг, урсгал засварын зардал 1.1 сая төгрөг,

Дотоод албан томилолт 0.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 18.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Буянт сумын Засаг даргын тамгын газарт 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Буянт сумын Засаг даргын тамгын газар 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд 176.5 сая төгрөгийн бараа материал, 18.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/04 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 797.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 370,886.3 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 176,014.3 мянган төгрөгийн гүйлгээг шилэн дансанд үнэн зөв мэдээлсэн байна. Мөн тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 120,644.2 мянган төгрөгийн 31 шийдвэрийн 2 шийдвэр буюу 22,000.0 мянган төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй ба шилэн дансны хэрэгжилт 93.5 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 2 шийдвэрийн 22,000.0 мянган төгрөгийн нөхөж байршуулах зөрчил арилгуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	117,235.0	2	117,235.0	100%
Зөвлөмж	2	160,067.7	2	160,067.7	100%
Нийт дүн	4	277,302.7	4	277,302.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өмч хөрөнгийн бүртгэл тооллого, шилэн дансны хөтлөлтийг анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 25.7 сая төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 3,698.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон

Буянт сумын Засаг даргын 2024 оны 07-р сарын 06-ны өдрийн А/46 дугаар захирамж, Буянт сумын Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 05-р сарын 03-ны өдрийн А/13 тоот тушаалаар 2024 оны 5 дугаар сард хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор 5 албан хаагчид 36,984,629 төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 3,698,463 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно”, 6.1.19-д “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг”, 28 дугаар зүйлийн 28.7-д “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.”,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21-р зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 370,886.3 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 176,014.3 мянган төгрөгийн гүйлгээг шилэн дансанд үнэн зөв мэдээлсэн байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 120,644.2 мянган төгрөгийн 31 шийдвэрийн 2 шийдвэр буюу 22,000.0 мянган төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансны хэрэгжилт 93.5 хувьтай байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан 22,000.0 мянган төгрөгийн 2 шийдвэрийг шилэн дансанд нөхөж байршуулан зөрчлийг арилгах, Шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар

сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын олгохдоо 3,698,463 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй	1	3,698.5	1	3,698.5								
Дүн	1	3,698.5	1	3,698.5								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хэрэгжилт хангалтгүй хэрэгжилт 93.5 хувьтай.	1	22,000.0			1	22,000.0		
Дүн	1	22,000.0			1	22,000.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

